МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 22 өдөр Дугаар А/939 Мандалговь хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хөрөнгөөр санхүүжих "Биеийн тамир спортын газрын өргөтгөлийн байрны дээврийн засвар"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Адъяасүрэн
(Худалдан авах ажиллагааны газрын дарга)

Гишүүд: М.Билгүүн
(Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл)

Нарийн бичиг: Э.Саранзаяа
(Худалдан авах ажиллагааны газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Адъяасүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж гэрээ байгуулсан өдрөөс хойш 28 хоногийн дотор холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Саранзаяа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Ариунбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.МӨНХЧУЛУУН

4225102569